



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 06 өдөр

Дугаар А/925

Мандлговь

Аймгийн баримтат уран сайхны
киноны зохиолч МУСГЗ До.Чулуунбаатарт
ажлын хөлс олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.1.5 "а", 30.1.17, Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1, Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, 16.1.3, 16.1.8, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5, Дундговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 1.2.1.5, аймгийн Стратеги төлөвлөгөөний 4.8 дахь заалт болон аймгийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 07 дугаар сарын 28 -ны өдрийн 11 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймаг байгуулагдсаны түүхт 80 жилийн ойг угтан бүтээж буй Дуу хуурын өлгий Дундговь аймгийн түүхэн үүсэл хөгжил, өв соёл, ёс заншил, зан үйл, түүх, соёлын дурсгал болон дурсгалт газруудыг баримтжуулан, нүүдэлчин Монголчуудын ахуй соёлыг шингээсэн баримтат уран сайхны киноны зохиолчид ажлын хөлс болох 10,000,000 (арван сая) төгрөгийг олгосугай.

2. Киноны зохиолчтой ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс(А.Нарантуяа) -т даалгасугай .

3. Киноны зохиолчийн ажлын хөлсөнд шаардагдах 10,000.000 (Арван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (М.Янжиндолгор) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210824